

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 100 ЖИЛИЙН ОЙ,
МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ГИШҮҮНЭЭР
ЭЛССЭНИЙ 50 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ИРЭЭДҮЙН АЖИЛ, МЭРГЭЖИЛ”
СЭДЭВТ ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Орчин үеийн аж үйлдвэр, техник технологийн хурдацтай хөгжил дэвшил, эдийн засгийн глобальчлал, орон зай, цаг хугацааны шийдэл, цаг уурын өөрчлөлт зэрэг нийгэм, эдийн засгийн хувьслыг даган, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага хурдтайгаар өөрчлөгдөж байна. Энэхүү өөрчлөлтийн хүрээнд нэг талаас хөдөлмөрийн зах зээлийн зарим ажил, мэргэжлийн хэрэгцээ багасах, өрсөлдөх чадвар буурах, бүр устан алга болж байгаа бол нөгөө талаас шинэ ажил мэргэжил бий болж, хэрэгцээ шаардлага нь нэмэгдэж байна.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага болон дэлхийн улс орнууд дээрх асуудалд анхаарал хандуулж, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, хэтийн төлөвлөлтдөө “ИРЭЭДҮЙН АЖИЛ, МЭРГЭЖИЛ”-ийг зохистой хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд бүтээмжтэй, хангалттай орлоготой, шударга, тогтвортой хөгжих боломж, бололцоог эрэлхийлэх үүднээс бодлогоо тодорхойлохыг эрмэлзэж байна.

ЗОРИЛГО:

Эссэ бичлэгийн уралдааны зорилго нь хүүхэд, залуучуудад хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл, ажил, мэргэжлээ зөв сонгож, түүндээ үнэн сэтгэлээс хандах ёс зүйн хүмүүжил, төлөвшлийг бий болгож хөгжүүлэх, хөдөлмөрч сэтгэлгээг идэвхижүүлэх, ирээдүйд бий болох ажил, мэргэжлүүдийн төсөөлөл, мэдээллийн цар хүрээг тэлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх замаар хүүхдүүдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ:

14-18 насны хүүхдүүд;

СЭДЭВ:

Ирээдүйн ажил, мэргэжил;

ХУГАЦАА:

2018 оны 11 дүгээр сарын 10 хүртэл;

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сэдвийн утга санааг тусгасан байх;
 - Үг үсэг, утга найруулгын алдаагүй байх;
 - Бусдын эссэ, зохион бичлэгээс хуулбарлаагүй байх;
 - MS word программ дээр Arial 12 фонтоор, мөр хоорондын зай 1.5-аар, эсхүл гаргац сайтай гараар бичсэн, 400-500 үгтэй байх.
- Эссэ бичлэгийн доор:**
- Уралдаанд оролцогч хүүхдийн овог, нэр, нас;
 - Холбогдох утасны дугаар /заавал бичих/-ыг бичсэн байна.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Ерөнхий зохион байгуулагч:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;

- Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага;
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо;
- Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо.

Хамтран зохион байгуулагч:

- Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газар;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт.

ШАГНАЛЫН САН:

- 1 дүгээр байр: өргөмжлөл, мөнгөн шагнал - 500 000 төгрөг;
- 2 дугаар байр: өргөмжлөл, мөнгөн шагнал - 400 000 төгрөг;
- 3 дугаар байр: өргөмжлөл, мөнгөн шагнал - 200 000 төгрөг.

Жич: Уралдаанд шалгарсан эссэ бичлэгүүдийн шагналыг 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр болох “**Ирээдүй ажил, мэргэжил**” зөвлөгөөний үеэр гардуулж, үзэсгэлэнд тавьж танилцуулна.

- **Эссэ бичлэгийг хүлээн авах хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Төрийн өмчийн 11 дүгээр байр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 213 тоот
- **Холбогдох утасны дугаар:** 62263093, 80027744, 86882222
- **Цахим хаяг:** ilo50years@fcy.gov.mn

---oOo---